



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот.

Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11.

Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315.

E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2023.01.19 № 03/254
танай 2023.01.09-ны № 04 -т

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ЭНХБАЯР
ТАНАА

Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 04 тоот албан бичгийн дагуу “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-ний дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  С.БАТБОЛД



080000213

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны
03/15/2023
01. дугаар сарын 15-ны өдрийн ... албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2020.07.01-НЫ 99 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР БАТЛАГДСАН "ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ
ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮГ БАГАСГАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ (2020-2022)
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорил ТОТ Түвшин н 2022 он	Хүрсэн түвшин	Гүйцэт эл, хувь	Хэрэгжилтийг харуусан байгууллага	Хамтран хэрэгжүү лсэн байгуул ага	Үнэлгэ э хувиар
			Он	Түвшин						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

Нийтлэг хэрэгжүүлэх ажил нь /Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны байгууллагууд хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг хэлж байгаа болно!

Зорилт 1. Эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах

1) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд "Байгууллагын эрүүл мэндийн үзлэг"-ийг хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах (ЭЭХДНЗБТАХАХТ 1.2)	Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах тухай заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоо -1	2020	Албан хаагчдын 80 хувийг хамруулах	Эмнэлгийн нарийн шинжилгээнд хамрагдах шаардлагатай 5 эрэгтэй албан хаагчийг тухайн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн	100%	ЗТХЯ	"УБТЗ" эмнэлэг	100%
---	---	--	------	------------------------------------	--	------	------	----------------	------

Хэрэгжилт: Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу яамны албан хаагчдыг 2022 оны 05 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Төмөр замын эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үзлэгт албан хаагчдын 35 нь эрэгтэй, 47 нь эмэгтэй албан хаагч хамрагдсан. Зам, тээврийн хөгжлийн яамны Хөдөлмөрийн дотоод журамд 2020 онд "Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байх заалт оруулсан. Иргэний нисэхийн ерөнхий газраас нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албан хаагчдыг улирал тутам хамруулж, Олон улсын гэрээ болон хөдөлмөрийн дотоод журамд эрүүл мэндийн үзлэгт хамрагдах талаар тусгасан байдаг.

Зорилт 2. Зам, тээврийн шалтгаант ослоос урьдчилан сэргийлэх замаар эрэгтэйчүүдийн осол, гэмтэл, нас баралтыг бууруулах											
2)	Интернэт орчинд эрэгтэйчүүдийн сонирхол, нас, амьдарч буй газар оронд тохирсон контентын шинэ хэлбэрийг ашиглан зам тээврийн осол, аваар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх (ЭЭХДНЗБ ТАХАХТ 2.4)	Гарын авлага 3 төрөл Хэвлэмэл хуудас-3000	Теле хэлэлцүүлэг-5 Радио хэлэлцүүлэг-3	2 арга хэмжээ зохион байгуулсан	2020	Замын хөдөлгөөний үндэсний зөвлөл Төвлөл өгөөнд тусгах	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар урьдчилан мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн	100%	ЗТХЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба	Тээврийн цагдаагийн алба	100%
Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2022 онд Тээврийн цагдаагийн алба, "Зариг" сайттай хамтран "5 хором" компанит ажлыг зохион байгуулж байгууллага хоорондын хэлэлцүүлгийг 3 удаа, телевизийн хэлэлцүүлгийг 5 удаа, радио хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, үйл ажиллагааг 5 сайгаар сурталчилж, 3 гарын авлага боловсруулан, 3000 ширхэг хэвлэмэл хуудас иргэдийн гарт хүргэсэн байна. Уг компанит ажлын хүрээнд ДЭМБ-тай хамтран 20 мянган ам.доллорын төсөл хэрэгжүүлж, суртагч багш нарыг бэлтгэхээр ЗТХСайдаар удирдаж батлуулж, сургалтыг 6 дугаар сарын 2-5- ны өдрүүдэд зохион байгуулсан											
Мөн ЗТХЯ-ны цахим хуудсанд зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг тогтмол байршуулж олон нийтэд хүргэж байна.											
Зорилт 3. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх мэдлэг, хандлага, дэдлэг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжих											
3)	Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.3)	Салбарын хэмжээнд спортын арга хэмжээ-2	Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан	2020	Зохион байгуулах арга хэмжээ 3-2	Салбарын хэмжээнд спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулж, бүх харьяа байгууллага хувийн хэвүлийн замын компаниуд оролцсон	100%	ЗТХЯ	"Монгол ын төмөр зам" ХНН "Монгол ын төмөр зам" ТӨХК	Хувийн хэвшил	100%
Хэрэгжилт: Зам, тээврийн салбарын спортын арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 23-12 сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж, харьяа 8 байгууллагын албан хаагчид 5 төрөлт тэмцээнд идэхитэй оролцож, салбарын аваргаа тодруулсан. "Монголын авто замчдын холбоо" ТББ-аас салбарын хэмжээнд 5 төрөлт спортын арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулахад зам, тээврийн салбарын Төр, хувийн хэвшлийн нийт 12 байгууллага оролцсон.											
4)	Эрэгтэйчүүдийн сонирхлоороо нэгдэж буй клуб, спортын төрлөөр дамжуулан стресс тайлах, сэтгэлзүйн зөвлөгөөг түгээх, зөв үлгэр дуурилал үзүүлж буй бүлэг, клубыг дэмжих, сурталчлах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.5)	Бүжгийн хамтлаг-1 Шагайн баг-1 Бэлтгэлийн өрөө-1	Клуб, спортын холбоотой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо-2	0	Зохион байгуулах арга хэмжээ 3-2	Шагайн харвааны баг албан ёсоор улсын чанартай тэмцээнд орсон.	100%	Зам, тээврийн хөгжлийн яам	Шагайн үндэсний холбоо	100%	
Хэрэгжилт: Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэд "Шагайн харваа" ны багийг хүсэл сонирхол бүхий албан хаагчид байгуулсан бөгөөд 2022 оны Улс хувьсгалын 101 жилийн ойн баяр наадамд анх удаа багаараа орсон. Шагайн харваа сонирхогчдод яамны 101 тоот өрөөнд бэлтгэл хийх зориулалттай булан тохижуулж, ажлын бус цагаар бэлтгэл хийх нөхцөлийг бүрдүүлсэн.											

Мөн яамны албан хаагчдаас сонирхлоороо бүжгийн багштай гэрээ байгуулан, бүжгийн сургуулилт хийж, яамны дэргэд бүжгийн хамтлагтай болж, бүжгийн анхны бичлэгийг хийлгэж хамт олондоо шинэ жилийн мэндчилгээ болгосон.

7) "Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр", "Стрессгүй ажлын байр" зэрэг аян өрнүүлэх замаар стрессийг даван туулах, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх сургалт, зөвлөгөө өгөх (ЭЭХДНЗБТАХАХТ 3.9)	Явган аялал Ууланд алхалт	-Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зохиосон үйл ажиллагааны тайлан-2	2022	-	2	Баг хамт олноороо хамтдаа стрессгүй ажлын байр бий болгох зорилт тавьсан.	100%	ЗТХЯ	Иргэний нисэхийн ерөнхий газар	100%
---	------------------------------	--	------	---	---	---	------	------	--------------------------------	------

Хэрэгжилт: Зам, тээврийн яамны албан хаагчид Өвөрхангай-Хархоринд түүх дурсгалын газартай танилцах аялалыг 2022 оны 08 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд аялалын явцад сэтгэцийн эрүүл мэнд стрессгүй ажлын байр-ны талаар мэдээлэл өгч ажилласан бөгөөд 45 албан хаагч хамрагдсан.

Мөн 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран "Эрүүл мэнд-стрессгүй орчин" арга хэмжээг зохион байгуулж ууланд алхах болон спортын арга хэмжээ зохиож, өдөрлөгийн үеэр сэтгэцийн эрүүл мэнд, стрессийг даван туулах талаар ойлголт мэдлэгийг яамны эмч Ш.Нямсүрэнгийн зүгээс өгч ажилласан бөгөөд 109 албан хаагч хамрагдсан.

Зорилт 4. Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийг өргөтгөн сайжруулах, хөвгүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг анхаарсан хөгжлийн төлөвлөлтийг эхлүүлэх

10) Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний байгууллага, Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд таниулах, олон улсын байгууллагын дэмжлэгээр чадавхжуулах (ЭЭХДНЗБТАХАХТ 4.5)	Хамтран ажиллах хэлэлцээр-1 Сургалт-1 "Тээвэрчдийн холбоо" ТББ-тай уулзалт-2	-Эрэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан; Хөвгүүд, эрэгтэйчүүдийг хамруулсан үйл ажиллагааны тоо-4	2020	-	-		100%	ЗТХЯ	Тээвэрч дийн холбоо ТББ	100%
---	--	---	------	---	---	--	------	------	-------------------------	------

Хэрэгжилт: Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2022.12.23-ны өдөр Монгол тээвэр холбоо газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоо, Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоо ТББ-тай нийгмийн гурван талт түншлэлийн хүрээнд 2023-2025 онд хамтран ажиллах хэлэлцээр байгууллаа. Уг хэлэлцээрт тээвэрчдийн ТББ-ын хүлээх үүрэг, тээвэрчдийн эрх ашгийг хамгаалах талаар хамтран ажиллах талаар тусгасан болно.

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/257 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж нүүрс тээврийн жолооч нарын эрхийг хамгаалах зорилго бүхий "Баянзам тээвэрчдийн холбоо" /УЗ-ийн дарга, П.Баярхүү/ болон "Жолооч автотээвэрчдийн ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн хороо /Хорооны дарга С.Батаа/-той нартай хамтран ажиллаж, нүүрс тээврийн жолооч нарын ажиллах орчин нөхцөлийн сайжруулах талаар 2022 оны 09 дүгээр сарын 28-10 дугаар сарын 06-ны Ажил олгогч нарт мэдээлэл өгч ажилласан.

Мөн тухайн Өмнөговь-Цагаанхад суурьшлын бүсэд эмнэлэг байгуулах талаар судалгаа хийж саналаа Эрүүл мэндийн сайд болон Өмнөговь аймгийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд мөн суурьшлын бүсэд Эмнэлэг байгуулах зориулалт бүхий газар олгох хүсэлтийг Засаг даргад хүргүүлсэн болно.

Хариуцан хэрэгжүүлэх ажил /Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас зөвхөн уг байгууллага хариуцан гүйцэтгэхээр, байгууллагын нэр нь орсон байгууллага өөрсдийн хийхээр төлөвлөгдсөн ажлыг хэлж байгаа болно/

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилготой түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Хэрэгжилтийг хариуцсан байгууллага	Хамтран хэрэгжүүлсэн байгууллага	Дэлгэрэнгүй тайлбар (Хэрэгжээгүй шалтгаан)
			Он	Түвшин						
Зорилт 2. Зам, тээврийн шалтгаант ослоос урьдчилан сэргийлэх замаар эрэгтэйчүүдийн ослол, гэмтэл, нас баралтыг бууруулах										
4) Олон улсын болон улсын чанартай авто зам дагуу камерын хяналтын системээр тээврийн хэрэгслийн хурд, бусад зөрчлийг хянах мэдээллийн нэгдсэн системийн програм хангамж, техник хангамжийн хөгжүүлэлт хийх (ЭЭХДНЗБТАХАХТ 2.1)	-	-Улсын хэмжээнд ашиглах (LPR) буюу тээврийн хэрэгслийн дугаарыг таньж илрүүлэх камеруудын мэдээллийг нэгтгэн хадгалдаг болсон байх; -100000 хүн амд ногдох зам, тээврийн ослын шалтгаант нас баралтыг 2 нэгжээр бууруулсан байна.	2020	-	-	-	-Цагдаагийн ерөнхий Газар	-ХЗДХЯ -ЗТХЯ	-	
Хэрэгжилт: Зам, тээврийн хөгжлийн яам дангаар хэрэгжилт гаргах боломжгүй										
12) Уул уурхай, дэд бүтцийн салбарт ажилладаг эрэгтэйчүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх аян, сургалт зохион байгуулах замаар ялангуяа уул уурхай, барилгын салбарын үйлдвэрлэлийн ослыг бууруулах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.10)	Сургалт-2	-Сургалтад хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо-80 гаруй тээврийн жолооч -Зохион байгуулсан мэдээлэл түгээх үйл ажиллагааны тоо-2	2020	Хамтран ажиллах гэжээ байгуулж байсан.	-	Жолооч нарын эрүүл аюулгүй байдлыг хангах талаар ажил олгогч нарт Мэдэгдэл хүргүүлсэн.	100%	ЗТХЯ	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	100%
Хэрэгжилт: Монгол улсын хэмжээнд тээврийн салбарын хяналтын улсын байцаагч нарт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр АТҮТ ТӨҮГ-ын хурлын танхимд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зөрчлийн онцлог” “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх” “Замын хар цэгийг тодорхойлох”, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шинжилгээ” сэдвээр сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 70 гаруй улсын байцаагч болон тээвэрчид, дунд сургуулийн багш нар тус тус хамрагдав.										

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/А/257 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомтын чиглэлд хийгдэж буй нүүрсний тээвэрлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, Цагаан хад суурьшлын бүс орчимд тээврийн жолооч нарын ажиллах нөхцөл, аюулгүй ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулах зорилготой ажилласан. Уг ажлын хэсгээс тээврийн жолооч нарт Хөдөлмөрийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлын тухай хуулийн талаар сургалт 2 удаа зохион байгуулсан. Мөн жолооч нарын ашигладаг нэгдсэн сошиал хаягт сургалтын материалыг байнга байршуулсан.

2022 он...01 сар...17 өдөр


ТАЙЛАН ГАРГАСАН:

Хуулийн хэлтсийн ахлах шинжээч
Нэр албан тушаал, гарын үсэг, тамга


С.Мяндасмаа

ХЯНАЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн
албан тушаалтны нэр албан тушаал, гарын үсэг, тамга


Н.Уугандулам